



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 07 сарын 06 өдөр

Дугаар 4/344

Мандалтөвь

Эмчилгээний ор дэлгэн  
ажиллуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6.л дахь заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4.5, 10.4.10 дахь заалт, 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.4 дэх заалт, Коронавируст халдвартын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7<sup>1</sup>.1 дэх заалт, Засгийн газрын 2021 оны 115,118 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Аймгийн хэмжээнд Коронавируст халдварт авсан иргэдийн тоо нэмэгдэж, эмчилгээний орны тоо хүрэлцэхгүй болсон тул аймгийн төв болон бусад сумдад эмчилгээний 544 орыг хавсралтаар баталж, дэлгэн ажиллуулахыг Эрүүл мэндийн газар (Б.Алтантөгс), эмнэлэг, Эрүүл мэндийн төвүүдийн дарга нарт даалгасугай.
2. Сургуулийн дотуур байранд ор дэлгэхтэй холбоотой гарах зарим зардлыг шийдвэрлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Энхтайван)-д даалгасугай.
3. Захирамжийн хэрэгжилтийг хангуйлж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (А.Нарантуяа), халдварт хамгааллын дэглэмийг хангуйлж хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат), эмнэлгийн хамгаалалт, аюулгүй байдлыг хангаж ажиллахыг Цагдаагийн газар (Г.Наранбаатар), сумдын Онцгой комиссын дарга нарт тус тус үүрэг болгосугай.
4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Анхбаяр)-т даалгасугай.



481210247

Аймгийн Засаг даргын 2021 оны 07 -р  
сарын 06 -ны өдрийн 14 дугаар  
захирамжийн хавсралт



**КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ТЭЙ ИРГЭНД ЭМНЭЛГИЙН  
ТУСЛАМЖ ҮЗҮҮЛЭХ ТҮР ОРНЫ ТОО**

д/д	Эмнэлэг эрүүл мэндийн төвийн нэр	Батлагдсан орны тоо	Дэлгэх орны тоо	Түр эмнэлэг дэлгэх байр
1	Нэгдсэн эмнэлэг	179	20	Нэгдсэн эмнэлэг халдвартын тасаг
			150	MCYT-ийн дотуур байр
2	Адаацаг ЭМТ	10	55	Амбултори, эмийн сан
3	Баянжаргалан ЭМТ	6	14	Эмнэлгийн байр
4	Говьугтаал ЭМТ	13	10	Эмнэлгийн байр
5	Гурвансайхан ЭМТ	10	10	Эмнэлгийн байр
6	Дэлгэрцогт ЭМТ	7	20	Дотуур байр
7	Дэрэн ЭМТ	10	10	Эмнэлгийн байр
8	Дэлгэрхангай ЭМТ	11	90	Хуучин эмнэлгийн байр
9	Сайхановоо ЭМТ	10	10	Хуучин эмнэлгийн байр
10	Луус ЭМТ	9	13	Цэцэрлэг
11	Цагаандэлгэр ЭМТ	9	10	Хуучин эмнэлгийн байр
12	Хулд ЭМТ	10	32	Хуучин эмнэлгийн байр
13	Өндөршил ЭМТ	8	10	Эмнэлгийн байр
14	Өлзийт ЭМТ	8	40	ЕБС дотуур байр
15	Эрдэнэдалай ЭМТ	19	50	Шинэ эмнэлэг
	Бүгд	319	544	